



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/111/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2025 оны 02 дугаар сарын 12

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.12 № 2/09

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

5020140

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас 95.6 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

המשרד המרכזי, ירושלים

תאריך: 6.10.2024



.. רצוננו להודיע לך

באשר להחלטתנו על אישור תוכנית הבריאות הלאומית לשנת 2024. תוכנית זו נועדה לשפר את רמת הבריאות הלאומית ולקדם את רווחת הציבור. תוכנית זו תכיל אמצעים שונים להקטנת הסיכון למחלות, לשיפור תזונה בריאה, ולקידום פעילות גופנית. תוכנית זו תהיה חלק ממתחם הבריאות הלאומית, המיושם באמצעות המשרד המרכזי ורשויות הבריאות המקומיות.

התוכנית תכיל אמצעים שונים להקטנת הסיכון למחלות, לשיפור תזונה בריאה, ולקידום פעילות גופנית. תוכנית זו תהיה חלק ממתחם הבריאות הלאומית, המיושם באמצעות המשרד המרכזי ורשויות הבריאות המקומיות. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו.

אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו.

בברכה,

המנהל הכללי, משרד הבריאות. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו.

אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו.

אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו.

אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו.

אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו. אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו.

אנחנו מקווים שתתמוך בתוכנית זו ותסייע לנו להשיג את מטרותינו.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>53,710,834.80</u>	<u>75,261,487.72</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,829,905.80	19,400,227.72
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,829,905.80	19,400,227.72
3121	Төгрөг	7,829,905.80	19,400,227.72
31211	Төрийн сангийн харилцах	7,829,905.80	19,400,227.72
33	АВЛАГА	173,423.00	426,809.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	173,423.00	426,809.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,707,506.00	55,434,451.00
351	Түүхий эд материал	17,536,561.00	16,562,796.00
35110	Тусгай зориулалттай материал	17,536,561.00	16,562,796.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	10,204,965.00	10,609,925.00
354	Хангамжийн материал	17,965,980.00	28,261,730.00
35410	Бичиг хэргийн материал	1,132,000.00	1,342,500.00
35420	Аж ахуйн материал	9,407,700.00	19,492,950.00
35430	Сэлбэг хэрэгсэл	49,500.00	49,500.00
35470	Бусад хангамжийн материал	7,376,780.00	7,376,780.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,047,033,430.06</u>	<u>1,844,518,973.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,047,033,430.06	1,844,518,973.50
392	Биет хөрөнгө	1,032,733,430.06	1,830,218,973.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	919,078,168.00	1,787,077,642.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-78,150,430.80	-93,780,516.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,000,000.00	28,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,000,000.00	-28,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	281,826,708.00	300,285,838.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-129,761,939.61	-196,767,833.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	78,583,000.00	78,583,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,399,968.93	-46,737,049.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,557,893.40	1,557,893.40
393	Биет бус хөрөнгө	14,300,000.00	14,300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,900,000.00	14,900,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,100,744,264.86</u>	<u>1,919,780,461.22</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,773,239.20</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,773,239.20	00.00
413	Өглөг	2,773,239.20	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,773,239.20	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,097,971,025.66</u>	<u>1,919,780,461.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,097,971,025.66	1,919,780,461.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,300,000.00	14,300,000.00
51101	Өмч: - төрийн	14,300,000.00	14,300,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	792,720,659.74	1,614,530,095.30

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	792,720,659.74	792,720,659.74
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	821,809,435.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	290,950,365.92	290,950,365.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,100,744,264.86</u>	<u>1,919,780,461.22</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,056,896,075.81	2,809,763,158.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,544,675.81	907,004,059.46
120	Нийтлэг татварын бус орлого	74,544,675.81	907,004,059.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,000,000.00	868,968,039.46
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,000,000.00	868,968,039.46
120009	Бусад орлого	7,829,905.80	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	982,351,400.00	1,902,759,099.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	971,640,400.00	1,675,740,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	971,640,400.00	1,675,740,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,711,000.00	227,018,799.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	26,963,999.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,711,000.00	200,054,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,073,472,181.02	1,987,953,722.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,073,472,181.02	1,987,953,722.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,073,247,181.02	1,749,223,589.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	727,569,500.00	1,176,669,069.00
210101	Үндсэн цалин	444,589,637.00	571,347,248.00
210102	Нэмэгдэл	193,428,568.00	420,014,328.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,727,967.00	134,726,339.00
210104	Урамшуулал	29,823,328.00	50,581,154.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,416,100.00	163,479,471.00
210201	Тэтгэврийн даатгал	112,381,300.00	121,254,371.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,508,700.00	10,556,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,207,000.00	5,278,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,301,700.00	5,278,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,017,400.00	21,112,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,511,039.20	72,779,727.39
210301	Гэрэл, цахилгаан	3,181,600.00	3,786,198.39
210302	Түлш, халаалт	62,752,239.20	66,489,819.00
210303	Цэвэр, бохир ус	2,577,200.00	2,503,710.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,827,880.00	20,976,001.49
210401	Бичиг хэрэг	11,881,880.00	10,616,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,300,000.00	4,301,500.00

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	2,637,901.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	650,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,496,000.00	2,220,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,170,000.00	3,435,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	335,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	420,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	1,750,000.00	2,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,901,154.50	27,526,629.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	6,467,514.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	83,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,330,000.00	3,960,000.00
210807	Газрын төлбөр	00.00	167,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,571,154.50	16,849,115.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,851,507.32	284,357,691.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.00	1,200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80,390,507.32	81,856,140.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	225,000.00	238,730,133.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	225,000.00	234,453,319.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	38,472,167.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	194,129,152.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	225,000.00	1,852,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	968,565.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	968,565.46
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,308,249.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,308,249.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-16,576,105.21</u>	<u>821,809,435.56</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,862,260.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-19,862,260.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-36,438,365.21</u>	<u>821,809,435.56</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,189,962,127.69</u>	<u>2,126,725,556.64</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	207,610,727.69	223,966,457.64
120	Нийтлэг татварын бус орлого	207,610,727.69	223,966,457.64

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	207,610,727.69	223,966,457.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	199,780,821.89	209,396,135.72
120009	Бусад орлого	7,829,905.80	14,570,321.92
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	982,351,400.00	1,902,759,099.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	971,640,400.00	1,675,740,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	971,640,400.00	1,675,740,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,711,000.00	227,018,799.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	26,963,999.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,711,000.00	200,054,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,182,132,221.89</u>	<u>2,115,155,234.72</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,182,132,221.89	2,115,155,234.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	982,126,400.00	1,665,616,350.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	727,569,500.00	1,187,170,328.00
210101	Үндсэн цалин	444,589,637.00	581,848,507.00
210102	Нэмэгдэл	193,428,568.00	420,014,328.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,727,967.00	134,726,339.00
210104	Урамшуулал	29,823,328.00	50,581,154.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,416,100.00	163,479,471.00
210201	Тэтгэврийн даатгал	112,381,300.00	121,254,371.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,508,700.00	10,556,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,207,000.00	5,278,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,301,700.00	5,278,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,017,400.00	21,112,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,737,800.00	76,300,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,181,600.00	3,786,198.39
210302	Түлш, халаалт	59,979,000.00	69,300,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,577,200.00	3,213,801.61
2104	Хангамж, бараа материалын зардал	19,946,000.00	24,720,000.00
210401	Бичиг хэрэг	12,000,000.00	12,400,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,300,000.00	4,301,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	2,820,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	650,000.00	1,400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,496,000.00	3,798,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,666,000.00	5,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,496,000.00	2,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	420,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	1,750,000.00	2,300,000.00
2107	Томилот, зочны зардал	00.00	200,000.00
210702	Дотоод албан томилот	00.00	200,000.00

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,330,000.00	6,300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,330,000.00	4,000,000.00
210807	Газрын төлбөр	00.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,461,000.00	201,946,551.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.00	1,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,005,821.89	449,538,884.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	225,000.00	236,834,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	40,453,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	194,129,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	225,000.00	2,252,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	199,780,821.89	209,396,135.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	968,565.46
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,308,249.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,308,249.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,829,905.80</u>	<u>11,570,321.92</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	7,829,905.80	11,570,321.92
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	7,829,905.80
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,829,905.80	19,400,227.72

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	828,985,601.95	00.00	1,134,235,967.87
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	828,985,601.95	00.00	1,134,235,967.87
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-36,438,365.21	00.00	-36,438,365.21
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	792,720,659.74	00.00	1,097,971,025.66
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	792,720,659.74	00.00	1,097,971,025.66
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	792,720,659.74	00.00	1,097,971,025.66
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	821,809,435.56	00.00	821,809,435.56
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	1,614,530,095.30	00.00	1,919,780,461.22



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,674,540,300.00	1,674,540,300.00	00.00	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,674,540,300.00	1,674,540,300.00	00.00	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,437,705,800.00	1,437,705,800.00	00.00	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,163,991,400.00	1,163,991,400.00	00.00	100.0
210101	Үндсэн цалин	629,866,000.00	581,848,507.00	48,017,493.00	92.4
210102	Нэмэгдэл	396,835,400.00	396,835,400.00	00.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	132,990,000.00	134,726,339.00	-1,736,339.00	101.3
210104	Урамшуулал	4,300,000.00	50,581,154.00	46,281,154.00	1,176.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,694,400.00	160,694,400.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	118,469,300.00	118,469,300.00	00.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	10,556,300.00	10,556,300.00	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,278,100.00	5,278,100.00	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,278,100.00	5,278,100.00	00.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	21,112,600.00	21,112,600.00	00.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,300,000.00	76,300,000.00	00.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,400,000.00	3,786,198.39	-386,198.39	111.4
210302	Түлш, халаалт	69,300,000.00	69,300,000.00	00.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	3,600,000.00	3,213,801.61	386,198.39	89.3
2104	Хангамж, бараа материалын зардал	24,720,000.00	24,720,000.00	00.00	100.0
210401	Бичиг хэрэг	12,400,000.00	12,400,000.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	4,301,500.00	-301,500.00	107.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,820,000.00	2,820,000.00	00.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,400,000.00	1,400,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,100,000.00	3,798,500.00	301,500.00	92.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,500,000.00	5,500,000.00	00.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,400,000.00	2,400,000.00	00.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	800,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	2,300,000.00	2,300,000.00	00.00	100.0
2107	Томиллолт, зочны зардал	200,000.00	200,000.00	00.00	100.0
210702	Дотоод албан томиллолт	200,000.00	200,000.00	00.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,300,000.00	6,300,000.00	00.00	100.0

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	2,000,000.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	100,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	4,000,000.00	00.00	100.0
210807	Газрын төлбөр	200,000.00	200,000.00	00.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	236,834,500.00	236,834,500.00	00.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	236,834,500.00	236,834,500.00	00.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,453,300.00	40,453,300.00	00.00	100.0
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	194,129,200.00	194,129,200.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,252,000.00	2,252,000.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,675,740,300.00	1,675,740,300.00	00.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,675,740,300.00	1,675,740,300.00	00.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,675,740,300.00	1,675,740,300.00	00.00	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	7,829,905.80	-7,829,905.80	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	19,400,227.72	19,400,227.72	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	227,018,799.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	227,018,799.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	223,710,550.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,178,928.00
210102	Нэмэгдэл	23,178,928.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,785,071.00
210201	Тэтгэврийн даатгал	2,785,071.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,746,551.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	197,746,551.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,308,249.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	227,018,799.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	227,018,799.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,963,999.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,054,800.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, “Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулах” зорилготой Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2024 онд бүртгэл хяналт, иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл чиглэлээр 38 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд тайлант онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 16,765 бүртгэл, эд хөрөнгийн 9,324 бүртгэл, хуулийн этгээдийн 2,359 бүртгэл бүртгэж баталгаажуулсан, 14,806 иргэнд тоо гарын үсэг олгож Дөт киоск машинаас 4,476 иргэн лавлагаа үйлчилгээ авсан байна. Мөн хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор 25 контент, 43 постер цацсан байна.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 онд дараах зорилтыг тавин ажилласан байна. Үүнд:

1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.

2. Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмж, түргэн шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.

3. Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.

4. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.

5. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах.

6. Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.

7. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.

8. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Дарга Ц.Мөнхжаргал, 2 дугаар гарын үсгийг ахлах нягтлан бодогч Г.Бат-Очир нар зурж, нярваар Р.Доржнямбуу ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг УБЕГ-ын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газар хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Оюуны өмч, УБЕГ-ын даргын 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Бодлогын баримт бичиг батлах тухай” А/904 тоот тушаалаар баталсан НББББ-ийг мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-1 стандартын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,919,780.5 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 819,036.3 мянган төгрөгөөр буюу 74.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	7,829.9	19,400.2	11,570.3
Авлага	173.4	426.8	253.4
Бараа материал	45,707.5	55,434.5	9,727.0
Үндсэн хөрөнгө	1,323,945.9	2,210,404.4	886,458.5

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
Хуримтлагдсан элэгдэл	(276,912.3)	(365,885.4)	(88,973.1)
Нийт хөрөнгө	1,100,744.3	1,919,780.5	819,036.3
Өр төлбөр	2,773.2	0.0	(2,773.2)
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	1,097,971.0	1,919,780.5	821,809.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,100,744.3	1,919,780.5	819,036.3

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 19,400.2 мянган төгрөг байгаа нь ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл байна.

Авлагын дансны эхний үлдэгдэл ажиллагсадтай холбогдсон 173.4 мянган төгрөгийн авлага барагдаж, авлага дансны эцсийн үлдэгдэл 426.8 мянган төгрөг байгаа нь ажиллагсадтай холбоотой цалингийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 55,434.5 мянган төгрөг болж өмнөх оноос 9,727.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 47,476.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн УБЕГ-аас 26,693.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, үйл ажиллагаандаа 64,443.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,844,519.0 мянган төгрөг болж 797,485.6 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 867,999.5 мянган төгрөгийн барилгын гадна, дотор, шугам сүлжээний их засварыг хийж, ТӨБЗГ-ын 2024 оны “Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 740 дүгээр тогтоолоор барилга байгууламж дансанд бүтгэсэн, УБЕГ-аас балансаас балансад шилжүүлсэн 18,459.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг ТӨБЗГ-ын 2024 оны “Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай” А-1/1108 дугаар албан бичгээр тоног төхөөрөмж дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны эхэнд 2,773.2 мянган төгрөгийн халаалтын өглөгтэй байсныг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 821,809.5 мянган төгрөгөөр өсөж 1,919,780.5 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,175,158.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 1,175,158.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 3 удаа тодотгон 500,581.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,675,740.3 мянган төгрөгөөр баталсан нь төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам олгох нэг удаагийн тэтгэмж болон цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,675,740.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,675,740.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн зардлын гүйцэтгэл 1,675,740.3 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа нь хэмнэгдсэн зардал 14,533.4 мянган төгрөгийн байгууллагын ахмадын сангийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт (хувь)
1	70406 Улсын бүртгэл, мэдээлэл	1,675,740.3	1,675,740.3	0.0	100.0
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,438,905.8	1,438,905.8	0.0	100.0
1.2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	236,834.5	236,834.5	0.0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс 25,964.0 мянга, УИХ-ын сонгуулийн санхүүжилт 29,908.6 мянга, орон нутгийн сонгуулийн санхүүжилт 170,146.2 мянга, шагналын 1,000.0 мянган төгрөг нийт 227,018.8 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрснийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж үлдэгдэл 763.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 69,300.0 мянга, гэрэл цахилгааны зардалд 3,400.0 мянга, цэвэр, бохир усны зардалд 3,600.0 мянга, шатахууны зардалд 4,000.0 мянган төгрөг батлагдаж “Эх бүрдэн” ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “Шунхлай” ХХК-тай шатахууны гэрээ, “Чандмань-Баянхонгор” ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаан, эрчим хүчээр хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 13/51 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсөв 1,675,740.3 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 1,675,740.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 25,136.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 16,338.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийг хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна. Аудитаар төрийн хэмнэлтийн хуультай холбоотой зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 1,452.0 мянган төгрөгийн 3 тушаал, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 26,595.9 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Даргын 2024.05.17-ны өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/06 дугаар тушаалаар нягтлан бодогчид балансын урамшуулал 2 сарын үндсэн цалин олгосон байна. Иймд дараагийн аудитаар дээрх урамшууллыг хавтгайруулан олгосон эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 29,499.9 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс, зөрчлийг арилгах 29,499.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 1,452.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14,874.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

5.2.1. УБЕГ-ын газрын даргын 2024.10.11-ний өдрийн "Нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмж олгох тухай" Б/579 дүгээр тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох шийдвэрээр цалингийн зардлаас 1,452.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, цаашид цалингийн зардлаас нэг удаагийн шинжтэй тусламж, тэтгэмж олгохгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг өгөв.

5.2.1. Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 1,452.0 мянган төгрөгийн 3 тушаал, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 26,595.9 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг өгөв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
УБЕГ-ын газрын даргын 2024.10.11-ний өдрийн "Нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмж олгох тухай" Б/579 дүгээр тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох шийдвэрээр цалингийн зардлаас 1,452,000 төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг зөрсөн байна.	1	1,452.0	-	-	1	1,452.0	-	-
Дүн	1	1,452.0	-	-	1	1,452.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 1,452.0 мянган төгрөгийн 3 тушаал, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 26,595.9 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	28,047.9	-	-	1	28,047.9	-	-
Дүн	1	28,047.9	-	-	1	28,047.9	-	-

-----oO-----